



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/28

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлах тухай 264 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Хангал, Гурванбулаг, Рашаант сум, Хялганат тосгонд “1 жуулчинд–1 хонь” төсөл хөтөлбөрт оролцох Nasdaily студийн Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хонг Конг мужийн инфлүүнсэрүүдийн (олон мянган дагагчтай) Монгол Улс дахь аяллын контент бүтээх ажлын гүйцэтгэгчээр “Зэгүн” ХХК сонгож гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Зэгүн” ХХК-ийн захирал (Б.Энхтогтох)-т даалгасугай.

3. Дээрх ажлын санхүүжилтийг 13,500,000 (арван гурван сая таван зуун мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

0324010038